



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 11 сарын 13 өдөр

Дугаар Б/36

Өмнөдэлгэр сум

О.Гантулгыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоол, Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны Хоринзургаа дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Очирбаатарын Гантулгыг 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс Засаг даргын Тамгын газрын жижүүрээр томилсугай.

2.Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандартыг чанд мөрдөн, албан тушаалын тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлж, идэвх санаачилгатай ажиллахыг /О.Гантулга/-д үүрэг болгосугай.

3.О.Гантулгад албан тушаалын тодорхойлолтыг танилцуулж, арга зүйн зөвлөгөө өгч, удирдлагаар ханган ажиллахыг нийгмийн бодлогын мэргэжилтэн /Т.Эрдэнэтуяа/-д хариуцуулсугай.

4.О.Гантулгын үндсэн цалин ТҮ-1 954,000 (есөн зуун тавин дөрвөн мянга) төгрөгөөр, орон нутгийн нэмэгдлийг 60 хувиар тооцож цалинжуулахыг нягтлан бодогч /Б.Гантулга/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Л.БАЯРМАА